



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 02 өдөр

Дугаар А/122

Амардалай

Үлийн цагаан оготной энгийн механикийн
аргаар тэмцэх ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 31.1.7, Байгалийн ургамлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, Ургамлын хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалт, Монгол улсын Засгийн газрын 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 185 дугаар тогтоол, Хүнс, Хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/143 тоот тушаал, Аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 10-ний өдрийн А/587 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын Баянбулаг, Цахиурт, Дэлгэр-Эмт багийн нутаг дэвсгэрийн үлийн цагаан оготной тэмцэх ажлыг байгаль орчинд халгүй, энгийн механик болон утах аргаар тэмцэх арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай

Ажлын хэсгийн ахлагч Б.Баттогтох (ХААТ-ийн мэргэжилтэн)

Б.Довуучий (1-р багийн Засаг дарга)

Г.Сосорбурам (2-р багийн Засаг дарга)

Б.Баатарсүрэн (3-р багийн Засаг дарга)

Б.Сармандах (ЖДҮ-ийн мэргэжилтэн)

2. Аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын санхүүжилтээр орж ирсэн 4,648,000 (дөрвөн сая зургаан зуун дөчин найман мянга) төгрөгийг үлийн цагаан оготной тэмцэх ажилд зарцуулахыг нягтлан бодогч (Г.Дэжидсүрэн)-д зөвшөөрсүгэй.

3. Үлийн цагаан оготной тэмцэх ажилд оролцсон 21 иргэний цалин хөлсний холбогдох материалыг бүрдүүлж олгохыг Хөдөлмөр халамж, үйлчилгээний мэргэжилтэн (Б.Энхдэлгэр)-т үүрэг болгосугай.

4. Үлийн цагаан оготной энгийн механик аргаар тэмцэх ажлыг товлосон хугацаанд нь үр дүнтэй зохион байгуулж тайлан мэдээг холбогдох газарт хүрүүлж ажиллахыг Ажлын хэсгийн гишүүдэд үүрэг болгосугай.

ДАРГА

М.БАЯРСҮХ